



ҮАГ

Үндэсний аудитын газар

Гадаадын зээл, тусламж, хандив, хөрөнгө оруулалтын бүртгэл, ашиглалт, зарцуулалт, үр дүн

Гадаадын зээл, тусламж, хөрөнгө оруулалтын бүртгэл, хяналт хангалтгүй байна.

УИХ-ын Эдийн засгийн Байнгын хорооны захиалга, Үндэсний аудитын газрын бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийсэн аудитын тайлан

Улаанбаатар 2006 оны 11 дүгээр сар

ҮАГ -1/2006/03-ГА

Агуулга

	Товчилсон үгсийн жагсаалт	3
<u>Тайланг бэлтгэсэн:</u>	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	4
ҮАГ-ын нэгдүгээр газар	Бүлэг 1 Гадаад зээлийн бүртгэл, хяналт хангалтгүй байна	
<i>Газрын захирал</i> <i>Д.Ганбилэгэ</i>		
<i>Аудитын менежер</i> <i>Ж.Батсайхан</i>	<ul style="list-style-type: none">• Танилцуулга	6
<i>Ахлах аудитор</i> <i>Г.Цэдэнбалжир</i> <i>Л.Одгэрэл</i>	<ul style="list-style-type: none">• Гадаад зээлийн өрийн үлдэгдлийг зөрүүтэй тайлагнажээ	7
<i>Аудитор</i> <i>Ц.Цэрэнхүү</i>	<ul style="list-style-type: none">• Зээл тусламжийн ашиглалт, үр дүнд тавих хяналт хангалтгүй байна	8
<i>Шинжээч</i> <i>Ц.Цолмон</i>	<ul style="list-style-type: none">• Зөвлөмж	9
2006 оны 11 дүгээр сар	Бүлэг 2 Дамжуулан зээлдүүлсэн зээл эргэж төлөгдөхгүй байна	
<i>Тайланг ҮАГ-ын вэб сайт-аас үзнэ үү:</i>	<ul style="list-style-type: none">• Танилцуулга	10
<u>www.mnao.pmis.gov.mn</u>	<ul style="list-style-type: none">• Зээл авсан аж ахуйн нэгж, төсөл хэрэгжүүлэгч байгууллага зээлийн төлбөрийг төлөх талаар санаачлагагүй ажиллаж байна	12
<i>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 261885 дугаарын утас, 323266 дугаарын факсаар харилцана уу.</i>	<ul style="list-style-type: none">• Дамжуулан зээлдүүлсэн зээлийн үйл ажиллагаанд оролцогч талуудын ажлын уялдаа холбоо хангалтгүй байна	14
ХАЯГ: <i>Үндэсний аудитын газар</i> <i>Засгийн газрын</i> <i>4 дүгээр байр,</i> <i>Бага тойруу-6,</i> <i>Улаанбаатар-46</i> <i>Монгол Улс</i>	<ul style="list-style-type: none">• Зөвлөмж	16
	Бүлэг 3 Буцалтгүй тусламжийг бүртгэх, ашиглах журам үгүйлэгдэж байна.	
	<ul style="list-style-type: none">• Танилцуулга	17
	<ul style="list-style-type: none">• Салбарын яамдад буцалтгүй тусламжаар хэрэгжиж байгаа төслийн бүртгэл Сангийн яамны бүртгэлээс зөрүүтэй байна	18
	<ul style="list-style-type: none">• Зөвлөмж	19

Агуулга

Бүлэг 4 Тусламжийн барааны орлого хугацаандаа төвлөрөхгүй байна

- Танилцуулга 20
- Зөвлөмж 22

Бүлэг 5 Гадаадын хөрөнгө оруулалттай компаниудын үйл ажиллагаанд тавих хяналт хангалтгүй байна

- Танилцуулга 23
 - Гадаадын хөрөнгө оруулалтын бүртгэл хийгдэж байгаа боловч нэгдсэн мэдээлэл, судалгаа хангалтгүй байна 24
 - Гадаадын хөрөнгө оруулалттай компаниудын үйл ажиллагаанд тавих хяналт муу байна 25
 - Гадаадын хөрөнгө оруулалтын үр дүнг тооцож чадахгүй байна 27
 - Зөвлөмж 27
 - Холбогдох байгууллагын санал 28
 - Хавсралтууд 30
-

Товчилсон үгийн жагсаалт

УИХ	Улсын Их хурал
ЗТАЖЯ	Зам тээвэр, аялал жуулчлалын яам
ДЗЗ	Дамжуулан зээлдүүлсэн зээл
АХБ	Азийн хөгжлийн банк
ДБ	Дэлхийн банк
ЯОУХАБ	Японы Олон Улсын Хамтын ажиллагааны банк
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БНЭУ	Бүгд Найрамдах Энэтхэг Улс
СЭЗЯ	Санхүү, эдийн засгийн яам
ҮХЯ	Үйлдвэр, худалдааны яам
ГХЯ	Гадаад хэргийн яам
ХХААЯ	Хүнс, хөдөө аж ахуйн яам
ОХУ	Оросын Холбооны Улс
УБТЗХНН	Улаанбаатар төмөр зам Хувь нийлүүлсэн нийгэмлэг
ИНЕГ	Иргэний нисэхийн ерөнхий газар
ТӨҮГ	Төрийн өмчийн үйлдвэрийн газар
УҮГ	Улсын үйлдвэрийн газар
МХХТГ	Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газар
ДБХЯ	Дэд бүтцийн хөгжлийн яам
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ХААҮЯ	Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яам
ГХОГХА	Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлаг
ҮТЕГ	Үндэсний татварын ерөнхий газар
УГЕГ	Улсын гаалийн ерөнхий газар
УМХГ	Улсын мэргэжлийн хяналтын газар
ГИХАЭА	Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх алба
НҮБХХ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр
ШУТИС	Шинжлэх ухаан технологийн их сургууль

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, хүндрэл бэрхшээл

УИХ-ын Эдийн засгийн Байнгын хорооны захиалга, Үндэсний аудитын газрын 2006 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Сангийн яам, Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлаг, дамжуулан зээл авсан зарим аж ахуйн нэгж, байгууллага, төсөл хэрэгжүүлэгч нэгжүүдийг хамруулан гүйцэтгэлийн аудит хийлээ.

Гадаадын зээл, тусламж, хандив, хөрөнгө оруулалтын бүртгэл, ашиглалт, зарцуулалт, үр дүнд дараахь чиглэлээр аудит хийн дүгнэлт гаргаж, үр ашгийг дээшлүүлэх санал зөвлөмж боловсруулан холбогдох байгууллагад хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдлээ. Үүнд:

- Гадаадын зээлийн ашиглалт, үр өгөөж
- Аж ахуйн нэгж, байгууллагад дамжуулан зээлдүүлсэн зээлийн ашиглалт, зарцуулалт
- Буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төслүүдийн үр нөлөө
- Хандив тусламжийн хөрөнгийн хуваарилалт, зарцуулалт
- Гадаадын хөрөнгө оруулалтын бүртгэл, хяналт, үр ашиг

Аудитын явцад холбогдох хүмүүстэй ярилцлага хийх, ажлын гүйцэтгэлийн баримт материалтай танилцаж, ажиглалт, дүн шинжилгээ хийх, тулган баталгаажуулах зэрэг гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглав.

Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэглэх аргачилсан зөвлөмж, гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитын явцад дараахь хүндрэл бэрхшээл учирч байлаа. Үүнд:

Сангийн яамны Төрийн сангийн газар болон Өрийн удирдлагын хэлтсээс дараахь судалгааг шаардлагын хэмжээнд гаргаж өгсөнгүй:

- Гадаад зээлийн хөрөнгийг дотоодод дамжуулан зээлдүүлсэн зээлийн үлдэгдлийн дэлгэрэнгүй бүртгэл, түүний дотор зээлийн гэрээ хийгдсэн болон гэрээ хийгдээгүй зээлдэгчийн жагсаалт

- Дамжуулан зээлдүүлсэн зээлийн гэрээ байгуулсан боловч зээлийн гэрээний үүргээ биелүүлээгүй аж ахуйн нэгжүүдийн жагсаалт
- Гадаад өрийн дарамтын талаар хийгдсэн тооцоо судалгаа


Мөн шаардлагатай бусад мэдээ, судалгаа, гэрээ хэлцэлтэй танилцахад бэрхшээл тулгарч байсан нь аудитыг цаг хугацаанд нь хийж гүйцэтгэхэд саад болсныг тэмдэглэж байна.

Бүлэг 1

Гадаадын зээлийн бүртгэл, хяналт хангалтгүй байна



Танилцуулга

1.1 Монгол Улс хөрөнгө оруулалтыг дэмжих, дэд бүтцийг хөгжүүлэх, улмаар улс орны эдийн засгийн хөгжилд түлхэц болохуйц төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зорилгоор хандивлагч орон, олон улсын санхүүгийн байгууллагуудаас 1991-2005 онд нийт 1,628.2 сая ам.долларын зээл авч ашиглажээ.



1.2 Эдийн засгийн хямрал, барааны хомсдол гарсан үед Монгол Улсын Засгийн газар гадаад орнуудын хөнгөлөлттэй зээл, тусламжийг 1991 оноос авч эхэлсэн бөгөөд тухайн онд 194,8 сая ам.долларын зээл авч байжээ.

1.3 Монгол Улс 1991-2005 онд гадаадын зээлээр нийт 114 төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлсэн бөгөөд үүнийг салбараар нь авч үзвэл:




1.4 Засгийн газар 2005 онд хандивлагч орон, олон улсын санхүүгийн байгууллагаас бүгд 180,2 тэрбум төгрөгийн зээл авч ашиглахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 109,8 тэрбум төгрөгийн зээл авч ашиглажээ. Энэ нь төлөвлөсөн хэмжээтэй харьцуулахад 70,3 тэрбум төгрөгөөр бага байна.

2005 оны гадаад зээлийн төлөвлөлт, ашиглалтын байдлыг хүснэгтээр харуулбал:

/тэрбум.төг/				
№	Зориулалт	Төлөвлөсөн	Ашиглалт	Зөрүү
1	Орон нутагт авто зам барих төсөлд	23,7	10,4	13.3
2	Бусад төслийн зээлд	120,9	88,6	32.3
3	Хөтөлбөрийн зориулалттай	20,5	10,8	9.7
4	Ядуурлыг бууруулах, өсөлтийг хангах	15,0	0	15.0
	Дүн	180.2	109.8	70.3

1.5 Ядуурлыг бууруулах хөтөлбөрийн хүрээнд Олон Улсын Валютын сангаас авахаар төлөвлөсөн 15,0 тэрбум төгрөг хугацаандаа орж ирээгүй учраас ашиглаж чадаагүй байна.

2005 оны гадаад зээлийн ашиглалтыг зээлдэгчээр харуулбал:



2005 онд авч ашигласан гадаад зээлийн 70 хувийг АХБ, ДБ, ЯОУХАБ-аас авсан зээл эзэлж байна.

Гадаад зээлийн өрийн үлдэгдлийг зөрүүтэй тайлагнажээ

1.6 Засгийн газрын тухай хуулийн 20.5.3-д заасны дагуу гадаадын зээл, тусламжийн нэгдсэн бодлогын төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохион байгуулалтын болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх ажлыг Сангийн яам хариуцаж байна.

Сангийн яамны Зээл, тусламжийн нэгдсэн бодлого, зохицуулалтын газар

- зээл тусламжийн бодлого, стратеги төлөвлөгөө боловсруулах,
- олон улсын байгууллага, хандивлагч орнуудтай хөгжлийн албан ёсны тусламжийн бодлого, хамтын ажиллагааны хөтөлбөрийг тохиролцох,
- хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийг тохиролцож баталгаажуулах,
- гадаадын зээл, тусламжийг зохицуулах хууль эрх зүйн орчныг сайжруулах, түүний хэрэгжилтийг зохион байгуулах,

Төрийн сангийн газрын Өрийн удирдлагын хэлтэс

- хандивлагч орон, олон улсын санхүүгийн байгууллагуудаас авсан гадаад зээлийн ашиглалтын хувь хэмжээг оновчтой тогтоох,

- дотоодын нийт бүтээгдэхүүн, экспорт, импорт зэрэг макро эдийн засгийн үндсэн үзүүлэлттэй уялдуулан Монгол Улсын гадаад зээл шингээх чадварын хязгаарыг тогтоох,
- өрийн удирдлагыг бэхжүүлэх, зээлийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулахтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийн төсөл боловсруулж, түүний хэрэгжилтийг зохион байгуулах чиг үүргийг тус тус гүйцэтгэж байна.

1.7 Өрийн удирдлагын хэлтэс гадаад зээлийн өрийн үлдэгдлийг зээлдүүлэгч болон ашиглагч байгууллагаар бүртгэж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулан нягтлан бодох бүртгэлд тусгуулах ажлыг хангалттай хийгээгүйгээс бүртгэл зөрүүтэй гарчээ.

1.8 Монгол Улсын Засгийн газрын нэгдсэн тайланд гадаад зээлийн өрийн үлдэгдэл 2005.01.01-ний байдлаар 1,628,6 тэрбум төгрөг байсан бол 2005.12.31-ний байдлаар 1,3 тэрбум ам.доллар буюу 1,587,3 тэрбум төгрөг болж 41,3 тэрбум төгрөг буюу 2,6 хувиар буурсан гэж тайлагнажээ.

1.9 Гэтэл ЗТАЖЯ-ны гадаад зээлийн өрийн үлдэгдлийг Сангийн яам тооцоо нийлж баталгаажуулаагүйгээс Засгийн газрын 2005 оны санхүүгийн нэгдсэн тайланд тус яамны гадаад зээлийн өрийн үлдэгдлийг 110,2 тэрбум төгрөгөөр илүү тусгасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.2, 5.1, 9.1 дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Зээл тусламжийн ашиглалт, үр дүнд тавих хяналт хангалтгүй байна.

1.10 Гадаадын зээл тусламжийг зохицуулах тухай хуулийн дагуу салбарын яамд гадаадын зээлээр хэрэгжүүлэх төсөл, түүний техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулж, Сангийн яам түүнийг нь хянаж, Засгийн газарт оруулан шийдвэрлүүлэх ёстой.

1.11 Хэдийгээр зээлийн гэрээ хуулийн дагуу хийгдэж байгаа ч салбарын яамд болон Сангийн яам сайтар хянахгүй байна.

Дэлхийн банкны зээлийн хөрөнгөөр санхүүжсэн Тээвэр сэргээх төслийн хүрээнд 1999 онд тээврийг хөгжүүлэх стратегийн баримт бичгийг боловсруулсан байхад АХБ-ны буцалтгүй тусламжийн хөрөнгөөр 2005 онд тээвэр хөгжүүлэх стратегийн баримт бичиг боловсруулах төсөл хэрэгжсэн байна.

1.12 Гадаадын зээлийн дийлэнх хувийг эдийн засгийн салбар, түүний дотор эрчим хүч, уул уурхай, автозамын салбарт зарцуулж байгаа бөгөөд зээлийн хөрөнгөөр нийлүүлэх сэлбэг хэрэгслийн дотор бусад байгууллагын сэлбэг хэрэгслийг оруулж захиалах явдал гарсан байна. Тухайлбал:

Монгол Улс, ЯОУХАБ-ны хооронд байгуулсан MON-P4 төслийн хөрөнгөөс 1998-2002 онд “Шивээ -овоо” Төрийн өмчит ХК-ийн нэр дээр Чойрын дэд станцын өргөтгөл, Чойр-Хар-Айргийн 110 квт-ын цахилгаан дамжуулах шугам, ШУТИС-ийн байгаль орчны лабораторийн багаж хэрэгслүүд зэрэг 4,1 тэрбум төгрөгийн сэлбэг хэрэгсэл нийлүүлэгдсэн байна.

Эрчим хүчний судалгаа хөгжлийн төвд Багануур, Шивээ-Овоогийн уурхайн шаардлагатай тоног төхөөрөмж сэлбэг хэрэгсэл гэж Япон Улсын буцалтгүй тусламжийн хөрөнгөөс 47,0 сая иен буюу 543,4 сая төгрөгийн, АНУ-ын тусламжийн хөрөнгөөс 18,5 сая төгрөгийн, бүгд 561,9 сая төгрөгийн сэлбэг хэрэгсэл нийлүүлэгдсэн бөгөөд өнөөг хүртэл ашиглалтгүй хадгалагдаж байна.

1.13 ОУВС, ДБ-ны мэргэжилтнүүдийн боловсруулсан гадаад өрийн дарамт буй эсэхийг тодорхойлдог шалгуур үзүүлэлтээр авч үзвэл манай улсын гадаад өрийн дарамт дунд хугацаанд сэрэмжлэх түвшинд хүрэхээр байна. Засгийн газрын шугамаар өмнө нь авсан гадаад зээлийн өр төсөв, төлбөрийн балансын алдагдлыг нөхөх, хөрөнгө оруулалт, санхүүжилттэй холбогдон үүсч ирсэн байна.

Зөвлөмж:

Сангийн сайд Н.Баяртсайханд дараахь зөвлөмж өгч байна:


- ✓ Зээлийн хөрөнгийг үнэн зөв бүртгэж, зээл ашиглагч байгууллагатай тооцоо нийлж баталгаажуулан нягтлан бодох бүртгэлд тусгаж байх.
- ✓ Зээлээр хэрэгжиж буй төслүүдэд тавих хяналтын тогтолцоог боловсронгуй болгох

Бүлэг 2


Дамжуулан зээлдүүлсэн зээл эргэж төлөгдөхгүй байна

Танилцуулга

2.1 Хандивлагч орон, олон улсын санхүүгийн байгууллагаас Монгол Улсын Засгийн газрын шугамаар 1991-2005 онд авч ашигласан 1,628.2 сая ам.долларын гадаад зээлийн хөрөнгөөс 1,0 тэрбум ам.долларыг дотоодын 350 гаруй (давхардсан тоогоор) аж ахуйн нэгж, төсөл хэрэгжүүлэгч байгууллагад дамжуулан зээлдүүлсэн байна.




2.2 Нийт гадаад зээлийн 62 хувийг эдийн засгийн салбарт дамжуулан зээлдүүлсэн зээл, 38 хувийг нийгмийн халамж, ядуурлыг бууруулах, эрүүл мэнд, боловсрол зэрэг салбарын зээл эзэлж байна. Дамжуулан зээлдүүлсэн зээлийг салбарын ангиллаар дор үзүүлэв.



2.3 Дамжуулан зээлдүүлсэн зээлийн дийлэнх буюу 67 хувийг зам тээвэр, эрчим хүч, уул уурхай, харилцаа холбооны салбарын зээл эзэлж байна.

Дамжуулан зээлдүүлсэн зээлийг зээлдэгчээр нь ангилбал:



Дамжуулан зээлдүүлсэн зээлийн ихэнх буюу 76 хувийг АХБ, ДБ, ЯОУХАБ олгосон байна.

2.4 Зөвхөн 1991-1995 онд бүгд 190 гаруй аж ахуйн нэгжид 238,3 сая ам.долларын гадаадын зээлийг дотооддоо дамжуулан зээлдүүлснээс 2005 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 20.6 хувь буюу 49.2 сая ам.долларыг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Үлдэх 79.4 хувь буюу 189,1 сая ам.долларын зээлийн улсын төсөвт эргэж төлөгдөх хугацаа нэгэнт дууссан бөгөөд гадаадад төлөх төлбөрийг зээл авсан байгууллагын өмнөөс улсын төсвөөс төлж байна.

2.5 Монгол Улсын Засгийн газрын нэгдсэн тайланд тусгагдсаны дагуу дамжуулан зээлдүүлсэн зээлийн үлдэгдэл 2005 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар 1000,7 тэрбум төгрөг, 2005 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 970,6 тэрбум төгрөг болж, зээлийн үлдэгдэл оны эхний үлдэгдлээс 30,1 тэрбум төгрөгөөр буурчээ.

2.6 Зээлийн өртэй 350 гаруй (давхардсан тоогоор) аж ахуйн нэгж, байгууллагаас 1991-2005 онд бүгд 116,7 тэрбум төгрөгийн үндсэн болон хүүгийн төлбөрийг буцаан төвлөрүүлсэн бол энэ хугацаанд гадаад орон, олон улсын банк, санхүүгийн байгууллагуудад бүгд 523.4 сая ам.долларын үндсэн болон хүүгийн төлбөрийг буцаан төлжээ.

2.7 2005 онд зээлийн үндсэн төлбөрт 27,0 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 18,3 тэрбум төгрөг, бүгд 45,3 тэрбум төгрөгийн гадаад зээлийн өрийг улсын төсвөөс төлсөн байна.

2.8 Дамжуулан зээлдүүлсэн зээлийг зээлийн зориулалт, олгосон хэлбэр, цаг хугацаагаар нь 2 хэсэгт хувааж болно. Үүнд:

- 1991-1995 онуудад импортыг хангах зориулалтаар бараагаар олгосон зээл
- 1996-2005 онуудад бүтцийн өөрчлөлтийг дэмжих зориулалтаар олгосон зээл

2.9 1991-1995 онд барааны хомсдолыг зохицуулах зорилгоор барааны хэлбэрээр зээл авч ашигласан байна. Тухайлбал:

- ✓ АХБ “Тусгай туслалцаа” “Аж үйлдвэрийг дэмжих” хөтөлбөр
- ✓ ХБНГУ “Барааны 1,2,3,4” зээл

- ✓ ДБ “Тусгай туслалцаа” “Эдийн засгийг дэмжих”
- ✓ Япон Улс “Мон-С1”, “Мон-С2”
- ✓ БНХАУ “Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх-1,2”, “Бараа барилга”
- ✓ БНЭУ “Монгол эмийн жижиг үйлдвэр”, “Цемент”, “Ургамлын тос”

Зээл авсан аж ахуйн нэгж, төсөл хэрэгжүүлэгч байгууллага зээлийн төлбөрийг төлөх талаар санаачлагагүй ажиллаж байна

2.10 Сангийн яам 2005 онд дамжуулан зээлдүүлсэн зээлийн үндсэн төлбөрт 16,0 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 6,8 тэрбум төгрөг, бүгд 22,8 тэрбум төгрөг улсын төсөвт төвлөрүүлсэн нь өнгөрсөн оныхоос 29,8 хувь буюу 6,8 тэрбумаар их байна.


2.11 Гэхдээ хандивлагч орон, олон улсын байгууллагаас зээл авсан 122 байгууллага өнөөг хүртэл дамжуулан зээлдүүлэх гэрээ байгуулаагүй бөгөөд гэрээ байгуулсан хэдий ч зээлийн төлбөрөө төлдөггүй 112 байгууллага байна. (Хавсралт 1)

2.12 Нийт дамжуулан зээлдүүлсэн зээлийн 35,0 хувь буюу 356,6 сая ам.долларыг эрчим хүч, уул уурхайн салбарт дамжуулан зээлдүүлснээс 2005 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар зээлийн гэрээний дагуу эргэн төвлөрөх ёстой 48.9 тэрбум төгрөгийн 11.4 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж, үлдэх 37,5 тэрбум төгрөг нь хугацаа хэтэрсэн зээл болж байна. Хугацаа хэтэрсэн зээлтэй аж ахуйн нэгж, байгууллагын судалгааг үзүүлэв. (Хавсралт 2)

2.13 Хавсралтад дурдсан 26 аж ахуйн нэгж, байгууллагын хугацаа хэтэрсэн нийт 37,5 тэрбум төгрөгийн зээлийн 42,7 хувь буюу 16,0 тэрбум төгрөг нь үндсэн зээл, 57,3 хувь буюу 21,4 тэрбум төгрөг нь хугацаа хэтэрсэн хүүгийн төлбөр байна.

2.14 Эрчим хүч, уул уурхайн салбарын аж ахуйн нэгж, байгууллагууд зээлийн төлбөрөө суутган тооцоо хийх замаар зээлийн өрийг барагдуулж байгаа бөгөөд бүгд 34,0 тэрбум төгрөгийн зээлийн өрийг барагдуулжээ.

2.15 Нийт дамжуулан зээлдүүлсэн зээлийн 25,0 хувь буюу 253,24 сая ам.долларыг зам, тээврийн салбарт олгосон дамжуулан зээлдүүлсэн байна.



2.16 Автозамын газар 2005 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар ДБ-аас олгосон 13,110,8 сая төгрөгийг дамжуулан зээлдүүлсэн зээлийн гэрээ хийж ашигласан боловч энэ зээлээс нэг ч төгрөг эргэн төлөөгүй байна.

2.17 ОХУ-ын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт 1992 онд олгосон валютын зээлээс УБТЗХНН 4,9 сая ам.долларыг авч ашигласан бөгөөд энэ зээлд

дамжуулан зээлдүүлэх гэрээ байгуулаагүй боловч зээлийн хөрөнгөөр Улаанбаатар, Толгойт өртөөний барилга, цахилгаан, дулааны тоног төхөөрөмж, УБТЗ-ын зангилгааны өргөтгөл, Сүхбаатар, Сайншандын 58 айлийн орон сууцны барилга гэх мэт объектуудыг ашиглалтад оруулж 2000 оны санхүүгийн тайлан тэнцэлдээ бүгд 4,7 сая ам.доллар буюу тухайн үеийн валютын ханшаар төгрөгт шилжүүлснээр 193,1 сая төгрөгийг УБТЗ болон харьяа байгууллагын үндсэн хөрөнгөд тусган харуулсан байна. Харин энэ зээл Сангийн яамны дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлагын дансанд УБТЗХНН-ийн нэр дээр 4.9 сая ам.долларын өрийн үлдэгдэлтэй хэвээр байна.

2.18 УБТЗХНН ЯОУХАБ-наас авсан зээл, зээлийн хүүгийн төлбөрийг төлөхдөө Монголбанкны албан ханшаар төлбөрийг гүйцэтгэж байсан бөгөөд 2005 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Сангийн яамтай тооцоо нийлж акт үйлдэхдээ зөвхөн төлсөн дүнгээр тооцоо нийлсэн бөгөөд зээлийн үлдэгдлээр тооцоогүй байна.

2.19 ЯОУХАБ-наас авсан MON-P1, MON-P2 зээл болон ДБ-ны зээлийн өрийн үлдэгдэлд валютын ханшны тэгшитгэлийг тухайн онд нь хийж байгаагүйгээс УБТЗХНН-ийн 2005 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайлан тэнцэлд дамжуулан зээлдүүлсэн зээл болох урт хугацаат зээлийн өрийн үлдэгдлийг 34,8 тэрбум төгрөгөөр дутуу тусгасан байна. Өөрөөр хэлбэл валютаар илэрхийлэгдсэн урт хугацаат зээлийн үлдэгдлийг анхных нь ханшаар нягтлан бодох бүртгэлд тусгаж байжээ.

2.20 Валютын ханшны тэгшитгэл хийгдээгүй 34,8 тэрбум төгрөгөөр урт хугацаат зээлийн өрийн үлдэгдлийг санхүүгийн тайлан тэнцэлд нэмэгдүүлэн тусгах, ОХУ-аас 1992 онд авсан 4,9 сая ам.долларын зээлийг төлөх талаар Сангийн яамтай 2006 оны 3 дугаар улиралд багтааж дамжуулан зээлдүүлэх гэрээ хийх албан шаардлагыг УБТЗХНН-ийн удирдлагад өглөө.

2.21 Нийт дамжуулан зээлдүүлсэн зээлийн 7 хувь буюу 73,9 сая ам.долларыг үйлдвэр, барилгын салбарт зээлдүүлсэн бөгөөд энэ зээлээс улсын төсөвт нэг ч төгрөг эргэн төлөгдөөгүй юм.

2.22 Хандивлагч орон, олон улсын байгууллагаас Монгол Улсын Засгийн газрын шугамаар авсан зээлийг дамжуулан зээлдүүлсэн судалгаа Сангийн яам болон зээл авсан зарим байгууллагын бүртгэлээс зөрүүтэй байна. Энэ нь дамжуулан зээлдүүлсэн зээл төлөгдөхгүй байх нэг шалтгаан болж байна.

2.23 Сангийн яамны дамжуулан зээлдүүлсэн зээлийн судалгаагаар ЯОУХАБ, Монгол Улсын Засгийн газрын хооронд 1991 онд байгуулсан MON-C1 хэлэлцээрийн 4.8 тэрбум иений зээлээс “Эрдэнэт концерн” УҮГ-т 2.3 сая ам.доллар, ДБ-наас 1993 онд Монгол Улсын Засгийн газарт олгосон 14.2 сая зээлжих тусгай эрхтэй тэнцэх зээлээс 3.5 сая зээлжих тусгай эрхтэй тэнцэх хөрөнгийг дамжуулан зээлдүүлсэн гэж бүртгэгдсэн ч зээлийн гэрээ олдохгүй байна.

2.24 Засгийн газрын 1991 оны 255, 332 дугаар тогтоолоор байгуулагдсан “Эрдэнэт концерн” УҮГ Засгийн газрын 1995 оны 235 дугаар тогтоолоор “Эрдэнэт концерн” ХХК болж, улмаар 2002 онд татан буугдаж “Мико холдинг” ХХК нэртэй болсон

байна. Уг компанийн удирдлагуудтай уулзаж зээлийн талаар тодруулахад зээл аваагүй гэсэн тайлбарыг 2006 оны 5 дугаар сарын 14-ний ЦС-06/03 албан бичгээр өгсөн болно. Мөн уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэр уг зээлийг аваагүй гэсэн тайлбарыг өглөө.

2.25 АХБ-наас 2004 онд “Авто зам засвар ашиглалтын нэгдэл” ХК-д олгосон 553,0 сая төгрөгийн зээлийг тус байгууллага тайлан тэнцэлдээ тусгаагүй байна.

Дамжуулан зээлдүүлсэн зээлийн үйл ажиллагаанд оролцогч талуудын ажлын уялдаа холбоо хангалтгүй байна

2.26 1991-1996 онд гадаадын зээл тусламжийн асуудлыг бие даан хариуцсан байгууллага байгаагүй бөгөөд Худалдаа үйлдвэрийн яам (хуучин нэрээр), Гадаад хэргийн яам, Хүнс, хөдөө аж ахуйн яам тус тусдаа хариуцаж байжээ.

2.27 Эдгээр яамд олгосон зээлийн талаархи баримт материалыг хагас дутуу бүрдүүлснээс зээл авсан зарим аж ахуйн нэгж, байгууллагын өрийн үлдэгдэл одоо ч тодорхой бус байна.

2.28 Тухайн үед ажиллаж байсан яамны удирдлага, ажил хариуцаж байсан ажилтнуудын хариуцлагагүй үйл ажиллагаанаас болж гадаадын зээлийн хөрөнгийг дотоодод дамжуулан зээлдүүлсэн зээлийн гэрээ зохих ёсоор хийгдээгүй нь зээлийн төлбөрийг төлүүлж чадахгүй байгаа үндсэн шалтгаан болж байна.

2.29 ХБНГУ, БНЭУ, БНХАУ зэрэг орноос авсан зээлээс бусад зээлүүдийг олгохдоо зээлдэгч аж ахуйн нэгжүүдтэй харилцан гарын үсэг зурж баталгаажуулсан зээлийн гэрээ, бусад баримт бичиг үйлдээгүй байна.

2.30 Нийт дамжуулан зээлдүүлсэн зээлийн 7,0 хувь болох 74,7 сая ам.доллар буюу 89,86 тэрбум төгрөгийг харилцаа холбооны салбарт дамжуулан зээлдүүлсэн байна.

2.31 Харилцаа холбооны салбарт 1999-2005 онд дамжуулан зээлдүүлсэн зээлийг төсөвт хэрхэн төвлөрүүлсэн байдлыг хүснэгтээр үзүүлбэл:

№	Огноо	Төвлөрүүлсэн орлого	Нийт зээл, зээлийн хүү	Зөрүү
1	1999	5,114,187,478	3,420,262,642	1,693,924,836
2	2000	5,355,763,600	4,862,840,515	492,923,085
3	2001	6,741,799,100	5,224,497,025	1,517,302,075
4	2002	7,672,613,450	5,917,182,916	1,755,430,534
5	2003	8,618,625,000	7,035,650,228	1,582,974,772
6	2004	7,885,401,363	7,626,873,919	258,527,444
7	2005	9,307,565,357	7,177,699,826	2,129,865,531
	Нийт дүн	50,695,955,348	41,265,007,071	9,430,948,277

2.32 Шуудан цахилгаан холбооны газар дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу 41,26 тэрбум төгрөгийн үндсэн зээл, хүүгийн төлбөрийн хамт төлж барагдуулжээ. Ингэхдээ зээлийн төлбөрийг жил бүр Сангийн сайдын тушаалаар төсөвт төвлөрүүлсэн түрээсийн орлогын тодорхой хувийг зээлийн төлбөрт тооцож, барагдуулж байжээ. Гэтэл Сангийн яам Шуудан цахилгаан холбооны газрын төлсөн төлбөрийг авлагын дүнгээс хасч тооцдоггүй байжээ.

2.33 АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр санхүүжигдсэн “Хөдөө орон нутгийг хөгжүүлэх” төслийг хэрэгжүүлэхээр 700,000 зээлжих тусгай эрхтэй тэнцэх зээлийг Мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн төв (хуучин нэрээр Шуудан цахилгаан холбооны газар)-тэй дамжуулан зээлдүүлэх гэрээ хийсэн боловч Төрийн сангийн газартай зээлийн болон хүүгийн хэмжээн дээр тохиролцож чадаагүйн улмаас уг зээлийг аваагүй байна. Гэтэл Сангийн яамны Төрийн сангийн газрын Өрийн удирдлагын хэлтэс дээрх зээлийг Мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн төв авсан мэтээр бүртгэсэн байна.

2.34 Дарханы төмөрлөгийн үйлдвэрт ДБ-ны зээлийн хөрөнгөөр хэрэгжсэн BESAC төслийн хүрээнд 1998 онд LSM 1408/2948 MOG дугаар дамжуулан зээлдүүлэх гэрээгээр 2.4 сая ам.долларын, Япон Улсын Засгийн газрын төслийн бус буцалтгүй тусламжаас 1996 онд 03 дугаар гэрээгээр 366.5 сая төгрөгийн, 2000 онд тус үйлдвэрийг барьж байгуулахад зөвлөх үйлчилгээ үзүүлсэн Японы Иточу компаний төлбөр болох 243,2 сая иен буюу 2662,7 сая төгрөгийн эргэн төлөгдөх зээл олгогджээ. Гэтэл тус үйлдвэр эдгээр зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг төлөөгүйн гадна Сангийн яам ч тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

2.35 Мөн Сангийн яамнаас гаргаж өгсөн судалгаагаар ДБ-ны дээрх төслийн хүрээнд 2947 MOG/LSM 407/01 дугаар гэрээгээр 1,94 сая ам.долларын, АХБ-наас 1244/MON(SF) LSM 1503/04 дугаар гэрээгээр 5,1 сая ам.долларын зээлийг тус үйлдвэрт олгосон гэх боловч тус үйлдвэр уг зээлийг аваагүй гэсэн тайлбар өгч тайлан тэнцэлд тусгаагүй байна.

2.36 Дамжуулан зээлдүүлсэн зээлийн эргэн төлөлт хангалтгүй байгаа нь дараахь шалтгаантай байна. Үүнд:

- Зээл авсан аж ахуйн нэгж, байгууллагууд хувьчлагдсан, өөрчлөн зохион байгуулагдсан, хуваагдсан, татан буугдсан, дампуурсан, төлбөрийн чадваргүй болсон, архивын материалууд нь устсан, шинэ өмчлөгч нь зээлийн хөрөнгийг хариуцахгүй гэдэг байна.
- Дамжуулан зээлдүүлсэн зээлийн хөрөнгийг 1991-1993 оны ам.долларын ханш 40-150 төгрөг байх үед олгосон бөгөөд зээлийн төлбөрийг тайлан тэнцэлд валютаар тооцож ханшны тэгшитгэлийг тухайн бүрт нь төгрөгөөр тооцож тусгаж байгаагүйгээс валютын ханшны зөрүү гарсныг зарим зээлдэгч хариуцахгүй гэдэг.
- Өмч хувьчлалын комисс /Төрийн өмчийн хороо/ төрийн өмчийн оролцоотой зарим аж ахуйн нэгжүүдийг хувьчлахдаа тайлан балансад тусгагдвал зохих гадаад зээлийн өрийн талаар Сангийн яамнаас санал авч байгаагүйн гадна тухайн объектын тайлан балансад гадаад зээлийн өрийг огт тусгаагүй, тусгасан ч Сангийн яамны тооцоотой тохирохгүй байна. Тухайлбал, ДБ-наас 1992-1993 онд олгосон хөнгөлөлттэй зээлээс “Агротехимпекс” ХК /хуучнаар ХААИХНэгдэл/-д олгосон 7,366,6 мянган ам.долларын зээлээс төсөвт 4,918,69 мянган ам.долларыг төвлөрүүлээд байхад 335,13 мянган ам.долларын авлагатай мэтээр хувьчилсан байна.

Зөвлөмж

Сангийн сайд Н.Баяртсайханд дараахь зөвлөмжийг өгч байна:

- ✓ Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн эргэн төлөлтийг сайжруулах зорилгоор бусад яамтай хамтран өр барагдуулах ажлын хэсэг байгуулан зээл авсан аж ахуйн нэгж байгууллагыг олж тогтоох, тооцоо нийлж актаар батлан гэрээг шинэчлэх, зээл авсан байгууллагуудад санхүүгийн үнэлэлт дүгнэлт өгч зээлийн нөхцлийг төлбөрийн чадвартай нь уялдуулан өөрчлөх, найдваргүй зээлийг тодорхойлж, хууль хяналтын байгууллагад хандан зохих журмын дагуу шийдвэрлэх,

Бүлэг 3

Буцалтгүй тусламжийг бүртгэх, ашиглах журам үгүйлэгдэж байна


Танилцуулга

3.1 Хандивлагч орон, олон улсын байгууллагаас Засгийн газрын шугамаар эргэн төлөгдөх нөхцөлгүй, хүмүүнлэгийн болон буцалтгүй, техник туслалцааны хэлбэрээр Монгол Улсад өгч буй тусламжийн хөрөнгийг Сангийн яам, холбогдох яам, агентлагтай хамтран хүлээн авч, ашиглалтад хяналт тавьж байна.

3.2 Буцалтгүй тусламжийн хөрөнгөөр улс орны эдийн засгийн өсөлтийг дэмжих, эрх зүйн шинэтгэлийг гүнзгийрүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэх, байгаль орчин, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, ядуурлыг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, үндэсний үйлдвэрлэл болон жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх, эрчим хүчний шинэ эх үүсвэр бий болгох, боловсролын шинэчилсэн стандартыг бий болгох зэрэг чиглэлээр 2004-2005 онд Монгол Улсын яамдын хэмжээгээр бүгд 90 төсөл хэрэгжиж байна. (Хавсралт 3)

3.3 Төслүүдийн амлалтын нийт төсөвт өртөг нь 149,8 мянган ам доллар бөгөөд 2006 оны 6 дугаар сарын 1-ний байдлаар нийт 66,7 мянган ам.долларын гүйцэтгэлтэй байгаа буюу нийт амлалтын 44,5 хувийг ашиглаад байна. Яамдаас Үндэсний аудитын газарт ирүүлсэн судалгаанаас үзэхэд энэ хувь хэмжээ 53,6 хувь байна.

3.4 Яамдын хэмжээгээр буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төслүүдийг 18 орон, олон улсын 8 байгууллагаас санхүүжүүлэн хэрэгжүүлж байна. Үүнийг диаграммаар үзүүлбэл:



3.5 Буцалтгүй тусламжийн төслийн хүрээнд хийгдсэн арга хэмжээ тодорхой үр дүнтэй байна. Эдгээрийн заримаас дурдвал:

- БНХАУ-ын буцалтгүй тусламжаар 2005 онд Замын-Үүд-Эрээний чиглэлийн 5,7 км хатуу хучилттай зам барьж ашиглалтад оруулсан.

- ХБНГУ-ын тусламжаар Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь Идэрийн гол дээр шинэ төрлийн бага хүчин чадалтай усан цахилгаан станц баригдаж байна.
- Япон Улсын буцалтгүй тусламжаар хөгжлийн бэрхшээлтэй 4000 гаруй иргэдийг хөдөлмөрийн зах зээлд татан оруулжээ.
- Голландын буцалтгүй тусламжаар малчдад бэлчээрийн менежментийн талаар зохих мэдлэг, дадлага олгож, 40 гаруй худаг засварласан байна.
- “Ногоон алт” хөтөлбөрийн хүрээнд Швейцарь улсын буцалтгүй тусламжаар Монголд ургадаг царгас, ерхөг зэрэг ургамлын дээжид шинжилгээ хийж, тэдгээрийг үржүүлэх, импортлох, бэлчээр, хадланг сайжруулахад ашиглаж болохыг тогтоосон байна.
- “Хүний нөөцийн тэтгэлэг” хөтөлбөрийн хүрээнд Япон Улсад жил бүр 20 хүнийг магистрийн сургалтад хамруулж байна.
- “Бага, дунд боловсролыг дэмжих” төслийн хүрээнд Япон Улсын буцалтгүй тусламжаар хөдөөгийн 3 сумын дунд сургуульд 7 компьютерыг дагалдах хэрэгслийн хамт нийлүүлж, сургуулийн 20 барилгад өргөтгөл хийсэн байна.
- Зудад нэрвэгдсэн Баянхонгор, Завхан, Дундговь аймгийн зарим сумдын сургуулийн барилгыг засаж, сургалтын орчныг сайжруулжээ.
- “Хөдөөгийн ядуурлыг бууруулах хөтөлбөр”-ийн хүрээнд шинээр 3 эмнэлэг, 1 сургууль барьж, 26 дотуур байр засварлажээ.
- “Эрх зүйн болон захиргааны салбарт дэмжлэг үзүүлэх” хөтөлбөрийн хүрээнд ХБНГУ-ын тусламжаар захиргааны хэргийн шүүхийн тогтолцоо бүрдүүлсэн.
- АХБ-ны буцалтгүй тусламжаар “Хөдөө аж ахуйн хөгжил” төслийн хүрээнд 38 хүнийг сургалтад хамруулж, 309 худаг сэргээн засварлаж, 20,0 сая га бэлчээрийг усжуулсан.
- Япон Улсын буцалтгүй тусламжаар ҮЖАТеатрын гэрэлтүүлэг, дууны тоног төхөөрөмжийг шинэчилсний гадна Палеонтологийн хүрээлэнд эртний амьтан, ургамлыг орчин үеийн судалгааны түвшинд боловсруулахад зориулагдсан 159 нэрийн тоног төхөөрөмж нийлүүлжээ.

Салбарын яамдад буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй төслийн бүртгэл Сангийн яамны бүртгэлээс зөрүүтэй байна

3.6 Сангийн яамнаас ирүүлсэн буцалтгүй тусламжаар хэрэгжиж байгаа төслүүдийн нэгдсэн судалгааг яамдаас ирүүлсэн судалгааны нэгтгэлтэй (Хавсралт 4) харьцуулж үзэхэд дараахь байдалтай байна.

/мянган ам.доллар/

№	Яамдын нэр	Сангийн яамны нэгдсэн судалгаагаар			Яамдын ирүүлсэн судалгаагаар		
		Нийт төслийн тоо	Амалсан хэмжээ	Үүнээс санхүүжүүлсэн дүн	Нийт төслийн тоо	Амалсан хэмжээ	Үүнээс санхүүжүүлсэн дүн
1	ХЗДХЯ	8	10888,9	6771,8	4	2405,0	846,0
2	ЗТАЖЯ	9	20744,2	5810,0	8	15325,0	5926,2
3	БОЯ	13	23666,3	6948,5	10	19883,7	9742,5
4	БХБЯ	3	3005,0	834,5	3	6820,0	4015,0
5	ЭМЯ	14	28998,5	17745,5	14	27894,8	16891,2
6	ГХЯ	1	661,6	193,6	-	-	-
7	ТЭХЯ	6	20890,0	10674,2	6	21190,0	13527,0
8	БСШУЯ	13	6243,6	1457,3	16	4380,1	3576,3
9	НХХЯ	4	10860,1	6469,9	7	8570,3	5255,0
10	ХХААЯ	8	15933,5	6873,1	12	44983,0	21830,2
11	ҮХЯ	8	5962,3	2848,1	3	3810,0	1868,2
12	СЯ	3	1930,9	128,9	2	630,9	128,8
13	БХЯ	-	-	-	-	-	-
	Нийт дүн	90	149784,9	66755,4	85	155892,8	83606,7

3.7 Сангийн яамнаас ирүүлсэн судалгааны гадаадын буцалтгүй тусламжаар хэрэгжиж байгаа төслүүдийн тоо, амалсан хэмжээ, үүнээс санхүүжүүлсэн дүн яамдаас авсан судалгаанаас зөрүүтэй байна. Өөрөөр хэлбэл яамдаас ирүүлсэн судалгаанаас 10 гаруй төсөл Сангийн яамны нэгдсэн бүртгэл, судалгаанд хамрагдаагүй байна.

3.8 Цаашид гадаадын буцалтгүй тусламжаар хэрэгжиж байгаа төслийн орлогыг зөв тодорхойлж, улсын нэгдсэн төсөв болон Засгийн газрын тайлан тэнцэлд тусгах, хөгжлийн албан ёсны тусламж, түүний үр дүнг олон нийтэд нээлттэй мэдээлж байх, үр ашигтай гэсэн техник, эдийн засгийн үндэслэл гарсан нөхцөлд төслийг авч байх шаардлагатай байна.

3.9 Хөгжлийн албан ёсны тусламжийн үр өгөөжийг сайжруулахад дан ганц Сангийн яам төдийгүй төсөл хөтөлбөрийг хариуцан хэрэгжүүлж буй салбарын яамд, агентлаг чухал үүрэгтэй бөгөөд тодорхой салбар дахь зээл, тусламжийн ашиглалт, үр өгөөжийн талаар хяналт тавих, Сангийн яаманд үнэн зөв мэдээлэх үйл ажиллагаа харилцан адилгүй, санхүүжилтийн мэдээг хожимдуулах, орхигдуулах, нууцлах зэрэг бэрхшээл гарсаар байна.

3.10 Гадаад орон, олон улсын байгууллагаас үзүүлж буй тусламжийн мэдээг бүртгэхэд улс орнуудын бүртгэлийн систем, санхүүгийн жилийн зөрөөнөөс шалтгаалан хүндрэл гардаг. Тухайлбал: Япон Улсын Гадаад хэргийн яам тусламжийн мэдээ тайланг 2 жилийн сүүлд гаргадаг, санхүүгийн жил зөрдөг. Иймд яам, түүний харьяа агентлагууд өөрийн салбарт хэрэгжиж буй төсөл хөтөлбөрт тавих хяналт, шинжилгээ, бүртгэх, мэдээлэх үйл ажиллагааг сайжруулах шаардлага тавигдаж байна.

Зөвлөмж:

Сангийн сайд Н. Баяртсайханд дараахь зөвлөмжийг өгч байна:

- ✓ Засгийн газрын шугамаар хэрэгжиж байгаа төслүүдийг бүрэн зөв бүртгэж, төслийн явц, үр дүнд тавих хяналтыг сайжруулах.

Бүлэг 4

Тусламжийн барааны орлого хугацаандаа төвлөрөхгүй байна

Танилцуулга

4.1 Монгол Улсын гадаад төлбөрийн тэнцлийг дэмжих, нэн хэрэгцээтэй бараа бүтээгдэхүүнийг нийлүүлэх зорилгоор гадаад орнуудын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт хүнсний болон төслийн бус буцалтгүй тусламжийг 1991 оноос хойш үзүүлж иржээ.

4.2 2004-2005 оны байдлаар тусламжийн барааны орлогын төлөвлөгөөний биелэлтийг хүснэгтээр үзүүлэв.

Тусламжийн барааны орлогын төлөвлөгөөний биелэлт

Сая.төг

№	Байгууллагын нэр	Эх/үлд	2004 он			2005 он			Эц/үлд
			Төл	Гүйц	Хувь	Төл	Гүйц	Хувь	
1	Эм импекс	1229.3	670.0	674.8	100.7	535.0	554.5	103.6	0
2	Хятадын буудай	821.9				805.5	821.9	102.0	0
3	Хар тарвагатай ХХК	231,6		10.0		9.0	10.0	111.1	211,6
4	Таван толгой	604.4				5.0	604.4		0
5	Авто импекс	584,5	20.0	41.2	206.0		9.0		534,3
6	Гурван гэгээн	138.1				91.5	138.1	150.9	0
7	МХХТГазар						1207,0		0
8	Эрдэнэт ДЦС	288,5	150.0	150.0	100.0		38.0		100,5
9	Тэвшийн говь	2.0		1.0			1.0		0
10	Шарын гол ХХК	8.0					8.0		0
11	Нарны үүсгүүр	5,522,9	250.0	347.3	138.9	885.0	898.8	101.6	4,276,8
12	НИК	3910.8	3800.0	3910.8	102.9				0
13	УНГ	652.7	480.0	652.7	136.0				0
13	ДЦС-3	226.0	200.0	226.0	113.0				0
14	ДЦС-4	38.0	30.0	38,0	126.7				0
	Дүн	14,258.7	5600.0	6051.8	108.1	2331.0	4290.7	184.1	5123,2

4.3 2005 оны Улсын нэгдсэн төсвийн тусламжийн орлогод 2331,0 сая төгрөг төлөвлөж, 4290,7 сая төгрөгийн гүйцэтгэл гарч, орлогын төлөвлөгөөг 84,1 хувиар давуулан биелүүлэхэд дараахь хүчин зүйлс нөлөөлжээ. Үүнд:

- МХХТГ-аас 2005 онд улсын төсөвт төвлөрүүлсэн түрээсийн орлогын төлөвлөгөөнөөс давсан орлого 1207,0 сая төгрөгийг Монгол Улсын Сангийн сайдын 2006 оны 58 дугаар тушаалаар тусламжийн орлогод тооцсон;
- СЭЗЯ, ДБХЯ, Өмнөговь аймгийн ЗДТГ, “Тавантолгой” ХХК-ний хооронд 2001 онд байгуулсан NPMG-05/06-08 дугаар гэрээний дагуу 2004 онд төлөгдөх ёстой тусламжийн барааны орлогын улсын төсөвт төлөх 604,4 сая төгрөгийг 2005 онд төлсөн;

- СЭЗЯ, ДБХЯ, Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын хооронд 2002 онд байгуулсан NPMG/01-22/06 дугаар гэрээний дагуу 2003 онд төвлөрүүлж дуусах ёстой байсан тусламжийн барааны орлогын үлдэгдэл 38,0 сая төгрөгийг 2005 онд төлсөн;
 - СЭЗЯ, ДХБЯ, Дархан-Уул аймгийн ЗДТГ, “Шарын гол” ХК-ийн хооронд 2001 онд байгуулсан NPMG-05/06-04 дугаар гэрээний дагуу 2004 онд төлөгдөх ёстой тусламжийн барааны орлого 8,0 сая төгрөгийг 2005 онд төлсөн.
- 4.4 2006 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар дор дурдсан 4 байгууллагаас бүгд 5123,2 сая төгрөгийн авлагатай байна. Үүнд:
- “Хар Тарвагатай” ХХК тусламжийн орлогын санд 211,6 сая төгрөг төвлөрүүлэх үлдэгдэлтэй байна.
 - “Авто импекс” ХК тусламжийн орлогын санд 534,3 сая төгрөг төвлөрүүлэх үлдэгдэлтэй байна.
 - Эрдэнэтийн дулааны цахилгаан станц 100,5 сая төгрөгийн өрийн үлдэгдэлтэй байгаа бөгөөд 2006-2007 онд төвлөрүүлж дуусах юм.
 - “100000 нарны гэр” үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2004 онд Япон, Хятад Улсын төслийн бус буцалтгүй тусламжаар нийлүүлэгдэж, малчдад олгогдсон үүсгүүрийн үнэ, нийт төвлөрүүлэх дүнгээс 4,276,8 сая төгрөгөөр дутуу байгаа нь орлого төвлөрүүлэх ажил Баян-Өлгий, Баянхонгор, Дорноговь, Сэлэнгэ аймагт хангалтгүй байгаагаас шалтгаалсан байна.
- 4.5 Гадаад орнуудаас төслийн бус буцалтгүй тусламжаар нийлүүлэгдэж байгаа барааны орлогыг төлөвлөх, зарцуулах, хяналт тавих, буцаан төвлөрүүлэх, бүртгэл, тайланд тусгах нэгдсэн журам байхгүй байна.
- 4.6 ХААҮЯ-наас хүсэлт тавьж, Японы тал зөвшөөрсний дагуу Сангийн сайдын 1998 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн 282 дугаар тушаалаар Дархан хотын “Дархан мах экспо” ХК-д (одоогийн нэр нь “Дархан хишиг” ХК) “Хүнсний хангамжийг сайжруулах КР-1” төслийн хуримтлалын сангаас эргэлтийн хөрөнгийн эх үүсвэрт зориулж 1 жилийн хугацаатай 500,0 сая төгрөгийн зээлийг олгосон боловч одоо болтол төлөгдөөгүй, 2006 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар үндсэн өр, хүү, алдангийн хамт бүгд 816,0 сая төгрөгийн зээлийн өрийн үлдэгдэлтэй байв.
- 4.7 Япон Улсын төслийн бус буцалтгүй тусламжийн орлогын сангаас тус компаний хөргүүрийн тоног төхөөрөмжийг шинэчлэхэд зориулж олгосон 595,0 мянган ам долларын зээл төлөгдөөгүй, 2006 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар үндсэн өр, хүү, алдангийн хамт бүгд 996,7 сая төгрөгийн зээлийн өрийн үлдэгдэлтэй байна.
- 4.8 “Дархан мах экспо” компани нь 2006 оны 10 дугаар сарын 4-ний өдөр ТӨХ-ны 532 дугаар тогтоолоор “Эрдшүр” ХХК-д хувьчлагдсан бөгөөд 500,0 сая төгрөгийн зээлийн үндсэн өр, хүү, алданги бүгд 816,0 сая төгрөгийн өрийг өмч хувьчлалын өр төлбөрийг барагдуулах жагсаалтад оруулж тооцоогүй байна.

4.9 1998 онд Япон Улсын буцалтгүй тусламжийн орлогын сангаас үйлдвэрлэл, худалдааны “Сүү” ХК, Сангийн яамны хооронд байгуулсан 98/11 дүгээр зээлийн гэрээгээр тус үйлдвэрт эргэлтийн хөрөнгийн эх үүсвэрт олгосон зээлийн үлдэгдэл 2006 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар үндсэн өр, хүү, алдангийн хамт бүгд 678,7 сая төгрөг байна.

Зөвлөмж

Сангийн сайд Н.Баяртсайханд дараахь зөвлөмжийг өгч байна:


- ✓ Гадаад орнуудаас төслийн бус буцалтгүй тусламжаар нийлүүлэгдэж байгаа барааны орлогыг төлөвлөх, зарцуулах, хяналт тавих, буцаан төвлөрүүлэх, бүртгэж тайлагнах журам баталж мөрдүүлэх

Бүлэг 5

Гадаадын хөрөнгө оруулалттай компаниудын үйл ажиллагаанд тавих хяналт хангалтгүй байна

Танилцуулга


5.1 2005 оны жилийн эцсийн байдлаар манай улсад нийт 88 гадаад орны 4814 аж ахуйн нэгж, компани үйл ажиллагаа эрхэлж 1,4 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийгдсэн байна. Нийт компанийн 55,1 хувь нь хамтарсан, 44,9 хувь нь гадаадын 100 хувийн хөрөнгө оруулалттай байна.




5.2 Гадаадын хөрөнгө оруулагчдаас оруулж байгаа хөрөнгө жилээс жилд өсөн нэмэгдэж байгаа бөгөөд 1990-2005 оны хөрөнгө оруулалтыг графикаар харуулбал:



5.3 Гадаадын хөрөнгө оруулалтын 686,8 сая ам. доллар буюу 48,1 хувийг геологи, уул уурхайн эрэл хайгуул, олборлолтод оруулсан хөрөнгө оруулалт эзэлж байхад гадаадын хөрөнгө оруулалттай компанийн ихэнх нь буюу 31,6 хувь нь худалдаа, нийтийн хоолны чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг компаниуд байна.



5.4 Гадаадын хөрөнгө оруулалтын 1,3 тэрбум ам. доллар буюу 95,0 хувь нь Улаанбаатар хотод төвлөрч байна. Нийт хөрөнгө оруулалтын 682,8 сая ам. доллар буюу 47,4 хувь нь БНХАУ-ын хөрөнгө оруулалт байна. Хөрөнгө оруулагч нарын эзэлж байгаа хувийг харуулбал:



Гадаадын хөрөнгө оруулалтын бүртгэл хийгдэж байгаа боловч нэгдсэн мэдээлэл, судалгаа хангалтгүй байна

5.5 Засгийн газрын 1991 оны 247 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсад гадаадын байгууллагын төлөөлөгчийн газар нээж ажиллуулах журам”-ын дагуу гадаадын хөрөнгө оруулалттай байгууллагыг бүртгэж зөвшөөрөл өгөх үйл ажиллагааг Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлаг хариуцан гүйцэтгэж байна.

5.6 2005 онд 988 гадаадын хөрөнгө оруулалттай компани, 32 төлөөлөгчийн газар шинээр бүртгүүлж 311,7 сая ам. долларын хөрөнгө оруулалт хийгджээ.

5.7 ГХОГХА-ын дэргэд гадаадын хөрөнгө оруулалтын нэг цэгийн үйлчилгээний төвийг 2000 оноос байгуулан ажиллуулж гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгуулахад бүрдүүлдэг 14 төрлийн баримт бичгийг 7 болгон багасгаж, хянан шийдвэрлэх хугацааг 60 хоног байсныг ажлын 3-7 хоногт багтаан үйлчилж байна.

5.8 Тус агентлагийн бүх үйл ажиллагааг хамарсан мэдээллийн бааз, түүнийг удирдах программ хангамжийг шинээр боловсруулан хэрэглэж байна.

5.9 2003 оноос хөрөнгө оруулагч гадаадын иргэний талаархи (овог нэр, нас, хүйс, мэргэжил, оршин суугаа хаяг, аль улсын харъяат болох, паспортын дугаар гэх мэт) мэдээлэл бүхий олон удаагийн виз, оршин суух зөвшөөрлийг олгоход зориулсан “ЦАХИМ КАРТ”-ыг нэвтрүүлснээр ГХОГХА, ГИХАЭА-ны ажлын уялдаа сайжирч компаний үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл сунгагдахад визийн зөвшөөрөл олгох эрх олгодог болсон байна.

5.10 ГХОГХА-ын даргын 2002 оны Б-1124 дүгээр тушаалаар “Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгуулах, бүртгэх, хөрөнгө оруулалтын гэрээг бүртгэх, тэдгээрийн үйл ажиллагаа, тайлан мэдээллийг зохицуулах журам”-ыг батлан мөрджээ. Гэвч энэ тушаалын 9 дүгээр зүйлд ГХОГХА, УТЕГ, УГЕГ, ГИХАЭА-наас судалгаа мэдээллийг нэгтгэн авч байхаар заасан нь хэрэгжээгүй байна.

5.11 Гадаадын хөрөнгө оруулалтын талаархи (компаниудын үйл ажиллагааны орлого, зарлага, ашиг, Монголын талд оногдож буй хувь, ажиллагсдын бүтэц, төлсөн татварын хэмжээ гэх мэт) мэдээллийг нэгтгэх хууль эрх зүйн орчин, байгууллага алга байна.

Гадаадын хөрөнгө оруулалттай компаниудын үйл ажиллагаанд тавих хяналт муу байна

5.12 Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуульд зааснаар гадаадын хөрөнгө оруулалтын холбогдолтой хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, хяналт тавих үүргийг Үйлдвэр, худалдааны яаманд хариуцуулсан байна. Тус яамнаас ГХОГХА-ын үйл ажиллагаанд мониторинг хийсэн байна.

5.13 Гадаадын хөрөнгө оруулалттай компани үйл ажиллагаандаа Компаний тухай хууль болон Монгол Улсын бусад хуулийг мөрдөж ажиллах бөгөөд Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 3-т “Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж гадаадын хуулийн этгээдийн салбарын санхүүгийн болон арилжааны үйл ажиллагааг Монгол Улсын хуулийн дагуу улсын санхүүгийн хяналтын байгууллага, эсхүл хяналтын зохих эрх бүхий хөндлөнгийн байцаагч хянан шалгана” гэсний дагуу УМХГ тавих ёстой байна.

5.14 УМХГ-аас 2005 онд гадаадын хөрөнгө оруулалттай эрүүл мэндийн 26, боловсролын 3 байгууллагад хяналт шалгалт явуулж Эрүүл мэндийн тухай, Эмийн тухай, Боловсролын тухай хуулиудын холбогдох заалтуудыг зөрчсөн талаар дүгнэлт гаргажээ.

5.15 2005 онд татварын хөнгөлөлтөд хамрагдсан 36 компаний 26 нь “Аж ахуй нэгж байгууллагын орлогын албан татварын тухай” хуулийн 7.6-д “бүтээгдэхүүн үйлдвэрлэн экспортод гаргасан” гэсэн заалтаар татвараас чөлөөлөгдсөн бол Авто замын салбарт 2, электроникийн салбарт 2, газрын тосны салбарт 2 компани бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу татвараас чөлөөлөгдсөн байна.

5.16 Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгуулахад Компанийн тухай хуулийн дагуу компаний өөрийн хөрөнгийн доод хязгаарыг хувьцаат компанид 10 сая төгрөг, хязгаарлагдмал хариуцлагатай компанид 1 сая төгрөгөөр тогтоосноор тэдгээрийн тоо олширч үйл ажиллагааг нь бүрэн хянаж чадахгүй болж, хөрөнгө оруулсан нэрээр зарим орны иргэд олноор оршин суух болсон байна.

5.17 Гадаадын хөрөнгө оруулалттай компани байгуулсан гэж Монгол Улсад удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөл авсан гадаадын хөрөнгө оруулалттай компанийн эзэд Монгол Улсын нутаг дэвсгэрт чухам ямар үйл ажиллагаа эрхэлж байгааг бүрэн хянаж чадахгүй байна.

5.18 Гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд Монгол Улсын хууль, эрхийн актыг зөрчиж байгаа эсэх, үйл ажиллагаагаа зохих зөвшөөрлийн дагуу явуулж байгаа болон татвараа төлж байгаа эсэх, үйл ажиллагаагаа явуулахгүй мөртлөө визийн хугацаагаа сунгуулж байгаа эсэхийг хянадаг байгууллага, механизм алга байна.

5.19 ГХОГХА гадаадын хөрөнгө оруулалтын гэрчилгээг сунгах, цуцлахдаа УТЕГ-аас татварын өртэй эсэх талаар тодорхойлолт авдаг байна.

5.20 ГХОГХА-д гадаадын хөрөнгө оруулалттай компанийн талаар бүхий л мэдээлэл байхад УТЕГ-ийн судалгаагаар тухайн компани үйл ажиллагаагаа эрхэлдэггүй, татварын өртэй, оршин суугаа хаягаараа олдохгүй байгаа зэргээр тодорхойлж байгаа нь УТЕГ, ГХОГХА-ийн хоорондын ажлын уялдаа хангалтгүй байгааг харуулж байна. Энэ талаар зарим баримтыг дурдвал:

- ГХОГХА-т 2005 онд гадаадын хөрөнгө оруулалттай 988 компани бүртгүүлсэн байхад УТЕГ-т 934 гадаадын хөрөнгө оруулалттай компани бүртгүүлсэн байна.
- 2005 онд УТЕГ-т бүртгэлтэй гадаадын хөрөнгө оруулалттай 148 компани хасагдаж, 587 компани 2005 онд үйл ажиллагаа явуулаагүй гэж тайлагнаж, 804 компани татварын тайлангаа хуулийн хугацаанд ирүүлээгүй байна.
- Нийслэлийн татварын газарт бүртгэлтэй хаяг байршилдаа байхгүй, олдохгүй байгаа 844,9 сая төгрөгийн татварын өртэй 540 компанийн 46,3 хувь нь гадаадын хөрөнгө оруулалттай компани байна.
- УТЕГ-аас гаргасан судалгааны дагуу 11 гадаадын хөрөнгө оруулалттай компанийн үүсгэн байгуулагч гадаадын иргэний оршин суугаа хаяг, байршлын талаархи судалгааг Гадаадын иргэн, харъяатын асуудал эрхлэх албанаас гаргуулахад зөвхөн 4 иргэн бүртгэлтэй байсан ба тэдгээрийн оршин суугаа хаяг УТЕГ-т байгаа бүртгэлээс зөрүүтэй байлаа.
- 1996 онд байгуулагдсан Бүх Хятадын Барилгын Ерөнхий компанийн 100 хувийн хөрөнгө оруулалттай “Хуа Хай Барилга Байгууламж” компани Нийслэлийн татварын газарт 2006 оны 1 дүгээр сарын 9-нд гаргасан тайлангаар 189,6 сая төгрөгийн татварын өртэй байжээ. Гэтэл Баянзүрх дүүргийн шүүхийн 2006 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 957 дугаар захирамжаар уг компанийн (өрөө төлөх хөрөнгөгүй тул) өрийг хүчингүй болгосон байна.
- 2002 онд байгуулагдсан “Атайр” ХХК-ийн Нийслэлийн татварын газар татвар төлөгчийн картад тэмдэглэсэн хаягаар нь олдохгүй, татварын байгууллагатай тооцоо хийхгүй байгаа гэж мэдээлсэн байхад ГХОГХА-ын бүртгэлд компанийн удирдлага нь 2005 онд солигдсон, 2006 оны 3 дугаар сарын 10 хүртэл гадаадын хөрөнгө оруулалтын гэрчилгээгээ сунгуулсан байна.

- Сүхбаатар дүүргийн татварын хэлтэст “Найрамдал интернейшнл” ХХК гаалийн татварын өртэйгээр мэдээлэгдэн шалгах гэхэд хаяг байршилдаа байхгүй олдохгүй байжээ. Гэтэл ГХОГХА-т байгаа мэдээллээр Сүхбаатар дүүргийн татварын хэлтсээс ирсэн 2005 оны 4 дүгээр сарын 29-ны 87 дугаар албан бичигт “татварын тооцоогүй” гэж тодорхойлсон учраас гэрчилгээг 2006 оны 7 дугаар сарын 21-ний өдөр хүртэл сунгасан байна. ГХОГХА-д тус компанийн хаяг, харилцах утас нь тодорхой байна.

Гадаадын хөрөнгө оруулалтын үр дүнг бүрэн тооцож чадахгүй байна.

5.21 ГХОГХА-ийн гаргасан сүүлийн 3 жилийн судалгаагаар гадаадын хөрөнгө оруулалт 13,4-23,9 хувиар өссөн байна.

5.22 2005 онд гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүдээс 81,5 тэрбум төгрөгийн татварын орлого, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн гэрчилгээний тэмдэгтийн хураамжийн орлого 9,0 сая төгрөг улсын төсөвт орсон байна.

5.23 Гадаадын хөрөнгө оруулалтын талаархи судалгааг ГХОГХА хийж байгаа боловч энэхүү судалгаа нь зөвхөн оруулсан хөрөнгө оруулалтын байдлаар хийгдэж байна.

5.24 Гадаадын хөрөнгө оруулалтын үр нөлөөг тодорхойлох арга хэмжээ аваагүй байна.

Зөвлөмж:

Монгол Улсын Засгийн газарт дараахь зөвлөмж өгч байна:

Нэг. “Гадаадын хөрөнгө оруулалтын тухай” хуульд дор дурдсан чиглэлээр нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг судалж шийдвэрлүүлэх. Үүнд:


- ❖ Гадаадын хөрөнгө оруулалттай компаниудад тавих хяналтыг сайжруулах, УМХГ, ГХОГХА, ҮТЕГ, УГЕГ, ГИХАЭА зэрэг байгууллагын хоорондын ажлын уялдааг сайжруулах,
- ❖ Гадаадын хөрөнгө оруулалтын талаархи нэгдсэн судалгаа, мэдээллийг бүрдүүлэх, үр дүнг тооцох байгууллагыг тодорхой зааж өгөх,
- ❖ Гадаадын хөрөнгө оруулалттай компанийг үүсгэн байгуулах дүрмийн сангийн хэмжээг нэмэгдүүлэх,

Хоёр.

- ❖ ҮТЕГ-т бүртгэгдсэн боловч үйл ажиллагаа эрхэлдэггүй, татварын өртэй, оршин суугаа хаягаа сольсон гадаадын хөрөнгө оруулалттай компаниудын талаар УГЕГ, ГХОГХА, ГИХАЭА хамтран шалгаж холбогдох арга хэмжээ авах

Холбогдох байгууллагын санал

Сангийн
яам



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОР Л.ЖАВЗМАА ТАНАА

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД
210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: 26-02-47, <http://www.mof.gov.mn>

2006. 10. 31 № 7-9/4563
танай 2006. 10. 13 -ны № 2/375 -Т


Тоотын хариу

Гадаадын зээл, тусламж, хандив, хөрөнгө оруулалтын бүртгэл, ашиглалт, зарцуулалт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Бүх төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн багцад хэрэгжиж байгаа төсөл, зээлийн үйл ажиллагаанд хяналт тавих, нягтлан бодох бүртгэлд тусгуулах, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэх үйл ажиллагаа хангалтгүй байгаад дүгнэлт хийж ирүүлсэн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх ажлыг Сангийн яамнаас үе шаттайгаар зохион байгуулах болно.

Засгийн газрын 2006 оны 185 дугаар тогтоолоор "Гадаад зээлийн хөрөнгийг дотоодод дамжуулан зээлдүүлэх журам"-ыг батлуулан мөрдөн ажиллаж байгаа учраас зөвлөмжийн 2 дугаар бүлгийн 1 дэх хэсгийг хасах саналтай байна.

Мөн зөвлөмжийн 3 дугаар бүлгийг гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр төсөл хөтөлбөр хэрэгжүүлж буй төсвийн ерөнхийлөн захирагч нарт хамруулан зөвлөмж өгөх нь зүйтэй гэсэн саналтай байна.

 Хүндэтгэсэн
САЙД 

Н. БАЯРТСАЙХАН

08 3756

Гадаадын
хөрөнгө
оруулалт
гадаад
худалдааны
агентлаг



МОНГОЛ УЛСЫН
ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ
ГАДААД ХУДАЛДААНЫ АГЕНТЛАГ

211238 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Самбуугийн гудамж 11,
Засгийн газрын XI байр, Утас: 32-60-40, 31-47-74, Факс: 32-40-76,
E-mail: fifta@investmongolia.com; <http://www.investmongolia.com>

2006.10.25 № 351
Танай 2006.10.13 -ны № 2/345 -т

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ
Б.БАТБАЯР ТАНАА

Санал хүргүүлэх тухай

Үндэсний аудитын газраас Гадаадын зээл, тусламж, хандив, хөрөнгө оруулалтын бүртгэл, ашиглалт, зарцуулалт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төслийн тус агентлагийн үйл ажиллагаатай холбогдох хэсэгтэй танилцаад дараах нэмэлт тайлбар, танилцуулгыг хийж байна. Үүнд:

1. Агентлагаас хуульд заасан чиг үүргийнхээ дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, идэвхитэй үйл ажиллагааны үр дүнд гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ жил бүр өсөн нэмэгдэж 1990 оноос хойш Монгол Улсад өссөн дүнгээр 1,5 тэрбум гаруй ам.долларын хөрөнгө оруулалт нийт 96 орноос их, бага хэмжээгээр хийгдээд байна. Энэ хөрөнгө оруулалтын тал шахам хувь нь өмнөд хөршийн хөрөнгө оруулагчдад ногдож байгаа бөгөөд цаашид хойд хөршийн болон бусад хөгжилтэй орнуудын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн тэнцвэржүүлэх бодлогыг нарийн зохицуулалтаар л хэрэгжүүлэх боломжтой гэж үзэж байна.

Анх цөөхөн салбарт орж байсан гадаадын хөрөнгө оруулалт одоо эдийн засгийн үйл ажиллагааны бараг бүхий л салбарыг хамрах болж нийгэм, эдийн засгийнх нь үр өгөөж нэмэгдэж байна. Харин гадаадын нийт хөрөнгө оруулалтын тавь шахам хувийг геологийн хайгуул, уул уурхайн салбарт орсон байгаа нь цаашид уул уурхайн бүтээгдэхүүнд нэмүү өртөг бий болгох, мал аж ахуйн гаралтай түүхий эдэд боловсруулалт хийж өрсөлдөх чадвар бүхий эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, эрчимжсэн газар тариалан хөгжүүлэх, орон сууцны цогцолбор, дагуул хот барьж байгуулах, аялал жуулчлалыг түлхүү хөгжүүлэх зэрэг Үндэсний хөгжлийн стратегид нийцүүлэн уялдуулан зохицуулж гадаадын хөрөнгө оруулалтыг татах шаардлагатай болж байна.

Тус агентлагаас хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх явцад дотооддоо эдийн засгийн үйл ажиллагааны бүх салбарын аж ахуйн нэгж, иргэд, төрийн бус байгууллагууд, Засгийн газрын агентлаг, яамдуудтай харьцах, Төрийн өндөр албан

1000748


тушаалтнуудтай шууд холбогдон ажиллах, цаашид улс орны хэмжээний дээр дурьдсан бодлогын шинжтэй үйл ажиллагааг зохистой хэрэгжүүлж байх шаардлага байгаа нь харагдсан юм. Гэвч тус агентлагийн эрх зүйн байдалтай уялдаж зарим хүндрэл учирдаг юм.

Нөгөөтэйгүүр, саяхан болж өнгөрсөн Монголын гадаад түншүүдийн Техникийн уулзалтын үед Монгол Улсын Сангийн сайд 2015 он хүртэлх хугацаанд Монголд 10 тэрбум ам.долларын гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэрэгцээ, шингээх чадвар бий гэж дүгнэсэн болно. Энэхүү зорилтыг хэрэгжүүлэх ГХОГХА-ийн үйл ажиллагааны цар, хүрээ нь өргөн, эрх зүйн байдлын хэмжээ зохих түвшинд байх шаардлагатай.

Хөрөнгө оруулалтыг дэмжих байгууллагуудын үйл ажиллагаа нь гадаадын хөрөнгө оруулалтын сурталчилгаа, бүртгэл үйлчилгээ хийх, дэмжихэд чиглэгдэж, хяналт шалгалтын ажилд оролцдоггүй олон улсын жишиг байдаг бөгөөд манай улсад УМХГ байгуулагдаж хяналт, шалгалтын нэгдсэн тогтолцоо бий болсон байна.

2. Жижиг эдийн засаг, зах зээлтэй манай орны хувьд гадаадын хөрөнгө оруулалтыг татахад улс орноо, хөрөнгө оруулалтын эрх зүйн орчин, боломжуудыг гадаадад байнга сурталчлах явдал онцгой ач холбогдолтой бөгөөд тус агентлагаас энэ чиглэлээр явуулж ирсэн идэвхитэй үйл ажиллагааны үр дүнд сүүлийн жилүүдэд жилд дундажаар 250 сая ам.долларын гадаадын хөрөнгө оруулалт Монголд орох болсон. Гэвч 2015 он хүртэл жилд наад зах нь 1 тэрбум ам.долларын гадаадын хөрөнгө оруулалт татах шаардлагатай болж байна. Өөрөөр хэлбэл, тус агентлаг нь томоохон хөрөнгө оруулагчдыг татах (гадаадын хөрөнгө оруулалттай компанийг үүсгэн байгуулах дүрмийн сангийн хэмжээг нэмэгдүүлэх), хөрөнгө оруулагчдын талаар мэдээлэл, судалгаа олж авах, тэдэнтэй харьцах, зөвлөгөө өгөх, хөрөнгө оруулалт эрэлхийлсэн төслүүдийг судлах, сурталчилах зэрэг үйл ажиллагаагаа улам нарийсган тодорхой чиглэл, зорилго, зорилттой ажиллах юм. Хөрөнгө оруулалтын талаарх өнөөгийн байдал, холбогдох байгууллагуудын хоорондын ажлын уялдааг сайжруулах нь тус агентлагаас үйл ажиллагаандаа зохицуулалт хийхэд чухал ач холбогдолтой. Иймээс тус агентлагийн орон тоог нэмэгдүүлэх, хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх зэрэг асуудал тавигдаж байгаа болно.

3. Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, холбогдох танилцуулгын хамт ҮХЯ-д хүргүүлээд байгаа бөгөөд түүнд аудитын тайлангийн төсөлд зөвлөмж болгосон гадаадын хөрөнгө оруулалттай компанийг үүсгэн байгуулах дүрмийн сангийн хэмжээг нэмэгдүүлэх, чиг үүрэгтээ үйл ажиллагааны зохицуулалт хийж байх зэрэг заалтууд тусгагдсан болно.



ДАРГА

Б.ГАНЗОРИГ



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2006 оны 11 сарын 10 өдөр

Дугаар 79

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах
тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13.4.5, "Гүйцэтгэлийн шалгалтын журам"-ын 23.2, "Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам"-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Гадаадын зээл, тусламж, хандив, хөрөнгө оруулалтын бүртгэл, ашиглалт, зарцуулалт, үр дүнд хийсэн аудитын тайланг баталсугай.

Хоёр. Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

Гурав. Аудитын тайланг УИХ-ын Эдийн засгийн Байнгын хороо, Монгол Улсын Ерөнхий сайд М.Энхболд, Сангийн сайд Н.Баяртсайхан, Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлагын дарга Б.Ганзориг нарт хүргүүлсүгэй.

Дөрөв. Аудитын тайланд тусгагдсан зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2006 оны 12 дугаар сарын 20-ны дотор Үндэсний аудитын газарт танилцуулахыг Монгол Улсын Ерөнхий сайд, Сангийн сайд, Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлагын дарга нарт зөвлөсүгэй.



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

Л.ЖАВЗМАА

070264

tushaal

САНГИЙН ЯАМНЫ БҮРТГЭЛЭЭР ХЭРЭГГИЖ БУЙ ГАДААДЫН БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖИЙН ТӨСЛҮҮДИЙН СУДАЛГАА

Хавсралт №4

мянган-ам доллараар

Яамдын нэр	Төслийн нэр	Эхлэх он	Дуусах он	Хандивлагч орон, байгууллага	нийт төсөв /мян.ам.доллар/	Үүнээс: ашигласан /мян. ам.дол/	Хэрэгжүүлэгч
ХЗДХЯ	Хуульчдын сургалт ба давтан сургалт	2003	2007	ХБНГУ	1200.0	686.0	ХЗДХЯ
	Эрх зүйн болон захиргааны салбарт дэмжлэг туслалцаа үзүүлэх зөвлөгөө өгөх 4-р шат	1995	2006	ХБНГУ	1200.0	400.0	ХЗДХЯ
	Эрх зүйн шинэтгэл, туслалцаа төсөл	2005	2005	Япон, ЖАЙКА	195.0	195.0	ХЗДХЯ
	Хүний эрхийн баталгааг сайжруулах	2001	2005	НҮБХХ	1177.9	1155.6	ХЗДХЯ
	Хилийн цэргийн холбоог сайжруулах	2003	2006	АНУ-ын аюулгүй байдал хамтын ажиллагааны газар	5000.0	2219.2	Хил хамгаалах ерөнхий газар
	Техник туслалцаа	2005	2005	НҮБ-н ДДКГ	2000.0	2000.0	Хил хамгаалах ерөнхий газар
	Цагдаа олон нийтийн хамтын ажиллагаа	2005	2005	Соросын сан	80.0	80.0	ЦЕГ
	Хүүхдэд ээлтэй хууль зүйн тогтолцоо	2005	2005	Дэлхийн Зөн	36.0	36.0	ХЗДХЯ
дүн				10888.9	6771.8		
ЗТАЖЯ	Зүүн чиглэлийн гол авто зам барих, холбогдох тоног төхөөрөмжийг сайжруулах	2005	2009	Япон	4450.0	498.7	ЗТАЖЯ
	Билэг хааны авто зам барих төсөл /Хархорин-хөшөө цайдам чиглэлд 46 км авто зам барих төсөл/	2005	2006	Турк	4700.0	27.5	ЗТАЖЯ
	Бүс нутгийн тээврийн дэд бүтцийг хөгжүүлэх төсөл	2005.6	2008	ХБНГУ	5989.2	553.8	ЗТАЖЯ
	Эрээн-Замын үүд чиглэлийн 5.68 км хатуу хучилттай зам барих	2005	2005	БНХАУ	3000.0	3000.0	ЗТАЖЯ
	ОУИНБ-ын Хойд Азийн бүсийн нислэгийн аюулгүй ажиллагаа, нислэгт тэнцэх чадварын хадгалалтыг хангуулах хамтын ажиллагааны хөтөлбөр	2003	2007	Boeng Company, Airbus, JAA, CAAC China, European Commision	305.0	200.0	ИНЕГ
	Иргэний нисэхийн салбарыг хөгжүүлэх Eastgate-2 шатны төсөл	2004	2007	Шведийн Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг	1750.0	1080.0	ИНЕГ
	Нислэгийн хөдөлгөөний удирдлагын төсөл	2005	2006	АНУ-ын Худалдаа хөгжлийн агентлаг	100.0		ИНЕГ
	Монгол Улсын тээврийн нэгдсэн стратеги боловсруулах төсөл	2005	2005	АХБ	300.0	300.0	ЗТАЖЯ

	Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замын ТЭЗҮ-ийн урьдчилсан судалгаа	2005	2005	АХБ	150.0	150.0	ЗТАЖЯ
	дүн				20744.2	5810.0	
БОЯ	Байгаль хамгаалал ба байгалийн нөөцийн тогтвортой менежмент-3	2002	2006	ХБНГУ, ГТХАН	6090.0		Хан Хэнтий ТХНГ
	Хот суурин газарт шинэ сайжруулсан зуухны хэрэглээг өргөтгөх	2001	2006	Дэлхийн банк, ДДБОС	750.0	551.4	БОЯ
	Дорнод Монголын биологийн төрөл зүйлийг хамгаалах	1998	2005	НҮБХХ, ДДБОС	6117.4	4458.1	БОЯ
	Алтай-Саяаны эко бүс нутгийн биологийн төрөл зүйлийг хамгаалах	2004	2008	НҮБХХ, ДДБОС	4700.0	374.7	БОЯ
	Хавтгайг төлөөлөл болгон Их говийн дархан цаазат нутгийн экосистемийг хамгаалах /Их говийн экосистем түүний шүхэр зүйлийг хамгаалах	2003	2007	НҮБХХ, ДДБОС	1034	490.3	БОЯ
	Удаан хугацаанд задарч хордуулах үйлчилгээтэй органик бодисын тухай Стокгольмын конвенцийг хэрэгжүүлэх	2003	2005	ДДБОС/UNIDO	362.0	362.0	БОЯ
	Эг-Үүрийн голуудын сав газрыг хамгаалах	2003	2008	ДДБОС	2000.0	310.9	БОЯ
	Байгаль орчны менежментийн чадавхийг орон нутаг болон үндэсний хэмжээнд дээшлүүлэх нь	2003	2006	ДБ	265.0	156.0	БОЯ
	Хамтын эзэмшлийн ойг боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэх нь	2004	2005	НҮБ-н Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага	56.5	53.5	БОЯ
	Нийтийн эзэмшлийн байгалийн нөөцийн тогтвортой менежмент 3-р үе шат	2004	2007	Канадын Олон улсын хөгжлийн төв	366.4	162.0	БОЯ
	Өгийн нуурын экосистемийг хамгаалах	2005	2010	Япон Улсын Засгийн газар ЖАЙКА			БОЯ
	Байгаль орчны шинэчлэл	2005	2006	Нидерландын Засгийн газар	1200.0	29.6	БОЯ
	Ойн ландшафтыг хамгаалах хөгжүүлэх төсөл	2005	2006	Нидерландын Засгийн газар	725.0		БОЯ
дүн				23666.3	6948.5		
БХБЯ	Газрын харилцааны салбарыг хөгжүүлэх, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх	2005	2007	Швед/Сида	1500.0	11.7	ГХГЗЗГ
	Газрын менежмент, санхүүгийн кадастрын төсөл	2005	2007	Герман			ГХГЗЗГ
	Дулааны хэмнэлттэй хувийн орон сууцийг зах зээлд нэвтрүүлэх төсөл	2001	2006	Норвеги, ДДБОС	1505.0	822.8	БХБЯ
	дүн				3005.0	834.5	
	Эрүүл мэндийн хөтөлбөр	2004	2005	ДЭМБ	3310.0	3302.9	ЭМЯ

ЭМЯ	Эрүүл мэндийн хөтөлбөр	2002	2006	НҮБХАС	3951.0	3107.0	ЭМЯ
	Нөхөн үржихүй	2001	2006	НҮБХАС	1022.0	885.4	ЭМЯ
	Эрүүл мэнд, хоол хүнс	2002	2006	НҮБ-н хүүхдийн сан	1600.4	1202.2	ЭМЯ
	Нөхөн үржихүйн эрүүл мэндийг дэмжих	1998	2006	Германы ТХА	4467.0	3102.0	ЭМЯ
	ХДХВ/ДОХ-оос урьдчилан сэргийлэх, Тусламж үзүүлэх үндэсний хөтөлбөрийг бэхжүүлэх	2003	2007	ДОХ, Сүрьеэ Хумхаатай тэмцэх Глобаль сан	1590.6	1590.6	ЭМЯ
	Эрүүл мэндийн салбарын мастер төлөвлөгөө төсөл	2003	2006	Японы олон улсын нийгмийн халамж үйлчилгээний корпораци	423.0	337.3	ЭМЯ
	Зүрх судасны төвийг бэхжүүлэх	2002	2006	Люксембургийн Вант Улс	1060.0	767.4	ЭМЯ
	Хөдөөгийн хүн амын эрүүл мэндийг сайжруулах, эрүүл мэндийн салбарыг шинэчлэх техник туслалцааны төсөл	2004	2007	Азийн Хөгжлийн Банк	1650.0	257.6	ЭМЯ
	Сэлэнгэ аймгийн хүн амд үзүүлэх анхан шатны тусламжийн чанарыг сайжруулах	2003	2006	Европийн хобоо, Санте Сюд байгууллага	1110.7	843.9	Францын Санте Сюд хүмүүнлэгийн байгууллага
	Монгол Улсад Сүрьеэтэй тэмцэх үйл ажиллагааг эрчимжүүлэх, олон эмийн дасалтай сүрьеэтэй тэмцэх	2003	2007	ДОХ, Сүрьеэ Хумхаатай тэмцэх Глобаль сан	1730.0	1015.8	ЭМЯ
	Олон эмийн дасалтай сүрьеэтэй тэмцэх	2005	2010	ДОХ, Сүрьеэ Хумхаатай тэмцэх Глобаль сан	4083.7	1020.4	ЭМЯ
	Орон нутгийн эрүүл мэндийн үйлчилгээний мэдээлэл, холбооны технологийг саайжруулах нь	2004	2007	АХБ	1000.0	312.9	ЭМЯ
	Хоол хүнсийг амин дэмээр баяжуулах төсөл	2004	2007	АХБ	2000.0		ЭМЯ
	дүн				28998.5	17745.5	
ГХЯ	Ардчиллыг шинээр болон сэргээн тогтоосон орнуудын олон улсын 5-р бага хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх төсөл	2004	2006	НҮБХХ	661.6	193.6	ГХЯ
	дүн				661.6	193.6	
	"Сэргээгдэх эрчим хүчний хөгжил"төслийн хүрээнд ТосонцэнгэлийнУЦС-370 кВт барих	2002	2006	ХБНГУ, ГТХАН	520.0	420.0	ГТХАН
	Эрчим хүчний салбарт ажиллагсадын сургалтыг сайжруулах	1998	2007	ХБНГУ, ГТХАН	8170.0	7572.2	ЭХСХТ
	Эрдэнэбулганы бага оврын УЦС-200кВт барих	2002	2006	Дани Улсын Засгийн газар	1000.0	920.0	Данийн сэргээгдэх эрчим хүчний хүрээлэн

ТЭХЯ	Цахилгаан тоног төхөөрөмжийг шинэчлэх	2003	2009	Чех Улсын Засгийн газар	2500.0	1037.0	ДЦС-4-ийн ТД цех, ШУТИС-н ЭХИС
	Богдын голын УЦС-н шинэчлэлтийн төсөл	2005	2006	ХБНГУ-СББ	3000.0	577.4	Сэргээгдэх Эрчим Хүчний Үндэсний Төв
	Дамжуулах сүлжээний шинэчлэлтийн төсөл	2004	2008	Швед Улс, Шведийн Олон улсын хөгжлийн агентлаг	5700.0	147.6	ТБЦДС ХК
	дүн				20890.0	10674.2	
БСШУЯ	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдий боловсролын стандартыг тогтоох	2004	2007	Шведийн Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг	55.6		БСШУЯ
	Хүний нөөцийн тэтгэлэгт хөтөлбөр	2002	2005	Япон	259.0	59.6	БСШУЯ
	Бага сургуулийн барилгын өргөтгөл төсөл	1999	2008	Япон	4562.6	503.0	JICE
	Боловсрол соёлын явуулын иж бүрэн үйлчилгээг малчдад хүргэх	2003	2006	ЮНЕСКО	190.9	190.9	БСШУЯ
	Зудад нэрвэгдсэн аймаг сумдын сургуулиудад туслах	2004	2005	ЮНЕСКО	200.0	111.6	БСШУЯ
	Өсвөр үеийн нөхөн үржихүйн эрүүл мэнд	2002	2006	НҮБХАС	489.9	227.7	БСШУЯ
	Багш сургах төлөвлөлтийг сайжруулах	2003	2006	Япон	402.2	300.0	БСШУЯ
	Хүний эрхийн боловсрол дунд сургууль	2005	2005	ЮНЕСКО-н Бээжин дэх төлөөлөгчийн газар			МУ-н Хүний Эрхийн Үндэсний Комисс
	Бичиг үсгийн боловсролыг зайн сургалтаар олго	2005	2006	ЮНЕСКО-н Бээжин дэх төлөөлөгчийн газар	22.5	20.5	БСШУЯ
	Бүх нийтийн боловсролын төлөвлөгөө боловсруулах	2004	2005	БНСУ-ын Итгэлийн сан, ЮНЕСКО	11.0	11.0	БСШУЯ
	ЮНЕСКО-ын Холбоот сургуулиудын үйл ажиллагааг эрчимжүүлэх нь	2004	2005	ЮНЕСКО-н Бээжин дэх төлөөлөгчийн газар	10.0	5.0	БСШУЯ
	Боловсролын шинэчилсэн стандартыг хэрэгжүүлэх, турших	2004	2005	ЮНЕСКО	18.0	18.0	БСШУЯ
	Бага насны хүүхдийн цогц хөгжил	2003	2006	НҮБ-н хүүхдийн сан	21.9	10.0	ЮНИСЕФ
	дүн				6243.6	1457.3	
	Нийгмийн хамгааллын салбарын хөгжлийн хөтөлбөр	2002	2007	АХБ	4000.0	2227.2	НХХЯ
	Нийгмийн хамгааллын салбарын хөгжлийн хөтөлбөр	2002	2007	Нордикийн хөгжлийн сан	4000.0	1620.0	НХХЯ
	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх төсөл	2002	2005	Япон Ядуурлыг бууруулах сан	1000.0	800.2	НХХЯ

НХХЯ	Ядуурлын судалгаа, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл	2001	2005	Шведийн Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг	1537.8	1516.5	НХХЯ
				НҮБХХ	196.3	180.0	НХХЯ
				Японы эмэгтэйчүүдийн сан	126.0	126.0	НХХЯ
	дүн				10860.1	6469.9	
ХХААЯ	Билчээрийн тогтвортой менежмент	2003	2007	НҮБХХ Голландын Засгийн газар	3115.4	1907.6	ХХААЯ
	"Ногоон алт" хөтөлбөр	2004	2008	Швейцарийн хөгжил хамтын ажиллагааны агентлаг	3735.0	837.5	ХХААЯ
	Францын хүнсний тусламжын сан	2003	2006	Франц	938.8	902.6	ХХААЯ
	Францын хүнсний тусламжын интервенцийн сан	2003	2006	Франц	125.4	5.0	ХХААЯ
	Хүнс ХАА-н үйлдвэрлэл эрхлэгчдэд зээл олгох ба үйлчилгээ үзүүлэх	2003	2006	Франц	148.0	233.3	ХХААЯ
	Сүү үйлдвэрлэлийн явцад гарах алдагдлыг багасгах замаар Монгол Улсын сүүний үйлдвэрлэл, хангамжийг нэмэгдүүлэх	2004	2007	Япон, НҮБ ХХААБ	1960.9	1255.0	ХХААЯ
	Хөдөө аж ахуйн үйлчилгээг сайжруулах	2004	2008	Европийн холбоо, ТАСИС хөтөлбөр	3500.0	1637.0	ХХААЯ
	Хоршооллын байгууллагын менежментийг сайжруулах төсөл	2005	2008	ХБНГУ	2410.0	95.1	ХХААЯ
	Худалдан авах чадварын индексийн тооцоог бол	2003	2006	АХБ	15	10.3	ҮСГ
дүн				15933.5	6873.1		
ҮХЯ	Экспортын баримжаатай үйлдвэр худалдааны бодлого	2004	2007	ХБНГУ, ГТХАН	2620.0	1206.0	ҮХЯ
	Жижэг дунд үйлдвэрлэлийг дэмжих	1998	2006	ХБНГУ, ГТХАН	5.0	5.0	ҮХЯ
	Бэлтгэл нийлүүлэлтийн сүлжээ	2004	2006	Европийн холбоо	1290.0	900.0	ҮХЯ
	Монголд үйлдвэрлэл хөгжүүлэе төсөл	2005	2008	НҮБХХ	1300.0	189.9	ҮХЯ
	Замтын нурууны геологийн масштабн зураглал, ерөнхий эрлийн ажил	2004	2007	БНЧУ-ын Хөгжлийн хамтын ажиллагааны нийгэмлэг	500.0	300.0	ҮХЯ
	Бичил уурхайг дэмжих	2005	2006	Швейцарийн хөгжил хамтын ажиллагааны агентлаг	0.9	0.8	ҮХЯ
	Газар зүйн заалтыг Монгол Улсад хэрэгжүүлэх	2005	2005	ДХБ	136.9	136.9	ҮХЯ

	ҮХЯ-ны Олон улсын худалдаа зах зээл судлалын төвийг бэхжүүлэх	2005	2006	ДХБ	109.5	109.5	ҮХЯ
	дүн				5962.3	2848.1	
СЯ	Монгол улсын татварын удирдлагыг бэхжүүлэх судалгаа	2006	2008	Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Агентлаг	1300.0		СЯ
	Ядуурлыг бууруулах стратегийн баримт бичгийн Итгэлцлийн сан: "Оролцооны үйл явцыг хангаж, жендэрийн асуудлыг уялдуулах нь" TF-053021	2003	2006	Дэлхийн банк, ОУХА	259.4	124.7	СЯ
	Хөгжлийн хамтын ажиллагааны үр ашгийг сайжруулах "МОН-05-105	2005	2007	НҮБХХ	371.5	4.2	СЯ
	дүн				1930.9	128.9	
	НИЙТ дүн				149784.9	66755.4	

САНГИЙН ЯАМНЫ ЗЭЭЛ ТУСЛАМЖИЙН НЭГДСЭН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

Хавсралт №2
(төгрөгөөр)

№	Зээлдэгч орон	Гадаад зээлийн дугаар	Төслийн нэр	Валют	Зээлийн хэмжээ	Хүүгийн хувь	Хугацаа хэтэрсэн		
							үндсэн төлбөр	хүүгийн төлбөр	Нийт
1	АХБ	1152 MON (SF)	ЭХУГ	SDR	2,600,656.69	2	545,554,658.3	559,856,643.9	1,105,411,302.37
2	АХБ	1334 MON (SF)	Дулааны 3-р цахилгаан станц	SDR	26,902,498.8	2		6,073,364,652.9	6,073,364,652.93
3	АХБ	1492 MON (SF)	УБ дулааны сүлжээ ХК	SDR	6,378,129.8	2	50,100,545.9	896,705,279.0	946,805,825.02
4	АХБ	1548 MON (SF)	УБ дулааны сүлжээ ХК	SDR	29,487,000.0	2		677,010,992.3	677,010,992.34
5	ДБ	2854 MOG	Багануурын нүүрсний уурхай	USD	31,126,560.9	4.2	2,803,907,281.5	1,306,520,818.0	4,110,428,099.58
6	ДБ	3503 MOG	УБ цахилгаан түгээх сүлжээ	USD	18,496,000.0	5.5		2,365,988,586.3	2,365,988,586.39
7	ДБ	3503 MOG	Ховд ЗДТГ, цахилгаан түгээх сүлжээ	USD	630,740.0	1		15,402,670.8	15,402,670.80
8	ДБ	3503 MOG	Хөвсгөл ЗДТГ, цахилгаан	USD	1,227,680.0	1		32,925,229.5	32,925,229.59
9	ДБ	3503 MOG	Баянхонгор ЗДТГ, цахилгаан	USD	617,830.0	1		17,812,485.2	17,812,485.24
10	ДБ	3503 MOG	Говь-Алтай ЗДТГ, цахилгаан станц	USD	418,180.0	1		11,523,065.4	11,523,065.40
11	ДБ	3503 MOG	Өмнөговь ЗДТГ, Даланзадгад цахилгаан станц	USD	592,070.0	1		16,686,491.2	16,686,491.25
12	ДБ	3503 MOG	Сүхбаатар ЗДТГ, Сүхбаатар эрчим компани	USD	713,490.0	1		20,266,389.9	20,266,389.99
13	ДБ	3503 MOG	Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК	USD	2,200,000.0	1		52,193,720.7	52,193,720.70
14	НХС	NDF-135	Дулааны 3-р цахилгаан станц	SDR	3,937,065.0	2	1,581,701,143.2	531,055,307.1	2,112,756,450.35
15	Япон	MON P3	4-р цахилгаан станц	JPY	4,493,000,000.0	2.5	1,003,791,367.5	281,537,638.6	1,285,329,006.17
16	Япон	MON P4	Багануурын нүүрсний уурхай	JPY	2,276,274,521.0	3	1,550,719,018.5	2,120,567,084.8	3,671,286,103.32
17	Япон	MON P4	Шивээ-Овоо нүүрсний уурхай	JPY	3,544,264,499.0	3	1,546,634,422.8	3,066,967,709.7	4,613,602,132.65
18	Япон	MON P5	Шивээ-Овоо ХК	JPY	4,298,000,000.0	2.5		2,600,078,922.3	2,600,078,922.36
19	Герман	9365123	Дарханы дулааны цахилгаан станц	EUR	710,816.8	0.75	154,673,198.7		154,673,198.79
20	Герман	9365255	ЭХУГ Дарханы ДЦС	EUR	4,601,626.9	0.75	1,461,767,491.8		1,461,767,491.85
21	Герман	9565862	ЭХУГ Дарханы ДЦС	EUR	2,556,459.4	0.75	463,581,992.7	16,869,319.8	480,451,312.60
22	Герман	9766031	Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК	EUR	7,669,378.2	0.75	2,190,766,568.1	31,803,551.0	2,222,570,119.15
23	Герман	200066183	Төвийн бүсийн цахилгаан дамжуулах систем	EUR	2,045,167.5	4	141,443.2	42,853.6	184,296.93
24	Герман	200066183	Диспетчерийн үндэсний төв	EUR	5,879,856.6	4	250,879,705.9	2,127,944.7	253,007,650.69
25	Герман	9766031 A	Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК	EUR	3,067,751.2	0.75	445,038,681.1	63,494,513.2	508,533,194.32
26	Солонгос	MON-2	Даланзадгадын цахилгаан станц	KRW	6,289,993,710.0	4	1,945,700,480.0	720,612,996.0	2,666,313,476.00
			Дүн				15,994,957,999.7	21,481,414,867.0	37,476,372,866.78